



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2023.09.01- 2023.09.29 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Тайлангийн дугаар: Хяналт/2023/29


Хэвлэсэн огноо: 2023.10.25

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Тус хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвөөс Улаанбаатар хотын хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын радио давтамжийн суурин хэмжилтийг стандартын шаардлагыг хангуулах, технологийн норм, горимыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, зорилгоор тогтмол хийж байна.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд	Харилцаа холбооны зохицуулах хорооны төв оффис, Метро бизнес төв А-блок 5 давхар, Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг,	/106°54'53.8"E 47°55'38.2"N/



Зураг 1. Хэмжилт хийсэн цэг.

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

KFSMS-2014 суурин хяналтын станц. /CN01162391/

4. Норматив бичиг баримт:


MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы нэвтрүүлэгч (VHF), техникийн шаардлага”

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Болдбат	ХХЗХ, РДӨНХТ	Суурин хяналтын инженер

Хэмжилтэд байлцсан			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Чагнаадорж	ХХЗХ, РДӨНХТ	Суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:




Зураг 2. Хэмжилт хийх үеийн зураг.


Тайлант хугацаанд төвийн давтамжийн хазайлт, төвийн давтамжийн шилжилт, эзэлсэн зурвасын өргөн гэсэн үндсэн үзүүлэлтээр хэмжигдсэн 28703 удаагийн хэмжилтийг нэгтгэн боловсруулж дундаж утгыг график хэлбэрээр Зураг 3, Зураг-4, Зураг-5-т үзүүлэв.

7. Хэмжилтийн дүн:


Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвөөс радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийж байна. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 34 аж ахуйн нэгжид 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд суурин хяналт хийснээс 7 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлтын утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, эдгээрээс 1 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, 2 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэх зурвасын өргөний утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, 1 радиогийн үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаагаа түр зогсоосон, 26 радиогийн үйлчилгээ эрхлэгч хэвийн ажиллаж байна.



Зураг 3. Давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлтын утга



Зураг 4. Нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт



Зураг 5. Эзэлсэн зурвасын өргөн

7.1. Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы нэвтрүүлэгч (VHF), техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх шилжилт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангасан дараах радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үүнд:

№	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	ДАВТАМЖ /МГц/
1	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22800192	88.3
2	СКОД ХХК	22800167	88.8
3	Сета тех ХХК	22800193	89.3
4	Жавзандамба хутагт төв ТББ	22800186	89.7
5	Улаанбаатар телевиз ХХК	22800178	90.5
6	Монгол комикс ХХК	22800159	91.1
7	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
8	Шүхэр ТББ	22800117	95.1
9	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
10	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
11	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
12	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд	22800071	97.5
13	Радиоком Монгол ХХК	22800025	98.1
14	*Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	22800029	98.5
15	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
16	Нью медиа ХХК	22800026	99.3
17	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	100.9
18	Агрегатор ХХК	22800022	101.7
19	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
20	Бадруун ХХК	22800006	102.5
21	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	103.1
22	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
23	Чугу ХХК	22800037	105.5
24	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	106.0
25	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6
26	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
27	Билэг санаа ХХК	22800018	107.5

*Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-ын 98.5 МГц радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаагаа түр зогсоосон байна.

7.2. Стандартын шаардлагыг хангаагүй:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлт /Deviation/-ын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн дараах радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх шаардлагатай байна. Үүнд:

№	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	ДАВТАМЖ /МГц/
1	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
2	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
3	Дижитал Радио ХХК	22800060	99.7
4	РФ ХХК	22800005	100.1
5	НС Холбоо ХХК	22800040	100.5
6	Медиа холдинг ХХК	22800009	103.6
7	Ви Өү Эм ХХК	22800052	104.0

Эдгээрээс 100.5 МГц радиогийн үйлчилгээ эрхлэгчийн нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, 92.1 МГц, 104 МГц радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэх зурвасын өргөний утга стандарт хэмжээнээс хэтэрсэн байна.

8. Дүгнэлт:

Дээрх стандартын шаардлагыг хангахгүй байгаа шалтгаан нь тухайн радиогийн нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тохиргооноос хамаарч байна. Иймд радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы цацаргалтын параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабел (фидер кабел, аудио кабел)-д тогтмол техникийн хяналт, үзлэг, үйлчилгээ хийж байх, студийн дууны холигч пультны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.